


**Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



# Хайрласны дараа ЮУ ХИЙХ ВЭ?

**Б**идний хайрт бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсон “хайр бол сайн мэдээний үндсэн зарчим”<sup>1</sup> хэмээн заасан байдаг.

Хайр үнэхээр чухал учраас Есүс үүнийг “агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал” гэж нэрлээд, хуулийн жижиг хэсэг бүр болон бошиглогчдын үгс үүн дээр тулгуурладаг хэмээн хэлсэн.<sup>2</sup>

Хайр нь бидний Сүм дээр хийдэг бүх зүйлийн гол шалтгаан болдог. Есүс Христийн шавийн хувьд бидний оролцдог хөтөлбөр, цуглаан, үйл ажиллагаа бүр энэ шинжийг агуулсан байх ёстой. Учир нь бид “Христийн цэвэр хайр” болох энэрэлгүйгээр хэн ч биш юм.<sup>3</sup>

Бид үүнийг оюун ухаан, зүрх сэтгэлээрээ ойлгон, Бурханд болон найз нөхдөдөө хайртайгаа харуулсны дараа яах вэ?

Бусдыг гэсэн энэрэл, хайрыг мэдрэх нь хангалттай юу? Бурханд болон хөршдөө хайртайгаа харуулах нь биднийг Бурханы өмнө хүлээсэн үүрэгтээ сэтгэл хангалуун болгодог уу?

## **Хоёр хүүгийн сургаалт зүйрлэл**

Иерусалимын ариун сүмд иудейчүүдийн ахлах тахилч, ахлагчид Есүсийг Өөрийнх нь үгээр унагахаар ирэв. Харин Аврагч нэгэн түүх ярьж өгөн, нөхцөл байдлыг давуу тал болгон хувиргасан юм.

“Нэгэн хүн хоёр хүүтэй байжээ” гэж Тэр эхлэв. Тэр ууган хүү уруугаа очиж, түүнээс усан үзмийн тариалан дээр ажилла гэсэнд хүү нь Үгүй гэжээ. Гэвч дараа нь гэмшиж, ажиллахаар явав.”

Мөнөөх хүн удаах хүүдээ мөн тэгж хэлэхэд хүү нь -За гэсэн атлаа явсангүй.

Дараа нь Аврагч ахлах тахилч, ахлагчид руу харж, “Тэр хоёрын аль нь эцгийнхээ хүслийг биелүүлсэн бэ?” гэж асуув.

Эхлээд татгалзсан ч дараа нь гэмшиж, усан үзмийн тариалан дээр ажиллахаар явсан ууган хүүг тэд хэлэх ёстой байсан.<sup>4</sup>

Аврагч зарлигуудыг дуулгавартай дагадаг хүмүүс нь Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс юм хэмээх чухал зарчмыг онцлохын тулд энэ түүхийг ашигласан юм.

Энэ нь Есүс хүмүүсийг фарисайчууд болон хуулийн багш нарын үгсийг сонсоод, дагаж болох ч тэдний үлгэр жишээг бүү дага хэмээн хэлсний шалтгаан ч байж болно.<sup>5</sup> Эдгээр шашны багш ярьдаг зүйлсийнхээ дагуу үйлддэггүй байв. Тэд шашны тухай ярих дуртай байсан ч мөн чанарыг алдагдуулдаг байсан нь харамсалтай.

## **Үйлдэл ба бидний аврал**

Аврагч шавь нартаа сүүлчийн хичээлүүдээ заах үедээ эцсийн шүүлтийн тухай ярьсан. Ёс бус хийгээд зөвт хүмүүс тусгаарлагдах болно. Сайн хүмүүс мөнх амьдралыг өвлөн авч, харин ёс бусчууд мөнхөд шийтгэгдэхээр хүргэгдэх болно.

Энэ хоёр бүлэг хүний хооронд ямар ялгаа байна вэ?

Хайраа үйлдлээрээ харуулсан хүмүүс аврагдсан. Харин хайраа үйлдлээрээ харуулаагүй хүмүүс буруушаагдсан.<sup>6</sup> Есүс Христийн сайн мэдээ, үүний үнэ цэн ба зарчмуудад жинхэнэ хөрвөгдсөн эсэх нь бидний өдөр тутмын амьдралын үйлдлүүдээр илэрхийлэгддэг.

Эцэст нь Бурханд болон найз нөхдөдөө хайртай гэдгээ хэлснээр л өргөмжлөлийг хүртэхэд хангалттай биш юм. Учир нь Есүсийн зааснаар “Эзэн минь, Эзэн минь

гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно.”<sup>7</sup>

### Хайрласны дараа юу хийх вэ?

“Хайрласны дараа юу хийх вэ?” гэсэн асуултын хариулт энгийн, шулуун шударга зүйл байж болох юм. Хэрэв бид Аврагчийг үнэхээр хайрладаг бол зүрх сэтгэлээ Түүнд хандуулж, дараа нь шавийн замаар алхдаг. Бид Бурханыг хайрласнаар зарлигуудыг нь сахихаар үргэлжлүүлэн хичээх болно.<sup>8</sup>

Бид найз нөхдөө үнэхээр хайрладаг бол “ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдад”<sup>9</sup> туслахад өөрсдийгөө зориулах болно. Учир нь энэрэнгүй байж, амин хувиа хичээхгүйгээр үйлчилдэг<sup>10</sup> хүмүүс л Есүс Христийн шавь нар мөн.

Энэ нь хайрласны дараа хийдэг зүйл.

Энэ бол Есүс Христийн сайн мэдээний үндсэн мөн чанар юм.

### ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Хайр бол сайн мэдээний үндсэн зарчим,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 109.
2. Матай 22:36–40-ийг үзнэ үү.
3. Моронай 7:46–47-г үзнэ үү.
4. Матай 21:28–32-ыг үзнэ үү.
5. Матай 23:3-ыг үзнэ үү.
6. Матай 25:31–46-г үзнэ үү.
7. Матай 7:21
8. Иохан 14:15-ыг үзнэ үү.
9. Сургаал ба Гэрээ 52:40-ийг үзнэ үү.
10. Мозая 18:8–9-ийг үзнэ үү.

### ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Угдорф Есүс Христийг болон бусдыг үйлдлээрээ хайрладаг хүмүүсийг Түүний жинхэнэ шавь нар хэмээн тодорхойлсон. Тэрээр “хэрэв бид Аврагчийг үнэхээр хайрладаг бол зүрх сэтгэлээ Түүнд хандуулж, дараа нь шавийн замаар алхдаг” хэмээн бидэнд заасан. Зааж байгаа хүмүүсээсээ хайр тэднийг шавийн замаар замнахад нь ямар арга замаар нөлөөлж байсныг асуух тухай бодож үз. Та бас тэдэнтэй туршлагаа хуваалцаж болно. Та тэднийг хайраар үйлдэхийн тулд илүү их энэрэл, хүч чадалтай байлгахын төлөө залбирахад урих тухай бодож болох юм.

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

### Зарлигуудыг дагаж, бусдыг хайрлах нь

**Б**иднийг хайрын тухай бодох үед оюун санаанд маань хамгийн түрүүнд ихэнхдээ романтик кино, шоколад, цэцэг орж ирдэг байж болох юм. Гэхдээ хайр гэгдэх жинхэнэ хайр нь үүнээс илүү гүн, аминч бус зүйл байдаг. Есүс Христ биднийг хайрладаг учраас бидний төлөө амьдарч, амиа өгсөн. Үнэн хэрэгтээ, хамгийн агуу хоёр зарлиг бол Бурханыг болон хүн бүрийг хайрлах явдал билээ (Матай 22:36–40-ийг үзнэ үү). Харин бид бусдыг хайрладаг гэдгээ тэдэнд хэрхэн харуулах вэ?

Ерөнхийлөгч Угдорф эцгийнхээ төлөө ажилласан болон ажиллаагүй хоёр хүүгийн тухай Христийн ярьсан сургаалт зүйрлэлийг хуваалцсан. Аврагч эцэгтээ дуулгавартай байсан тэр хүү л эцгээ үнэхээр хайрладаг байсан хэмээн онцлон хэлсэн юм. Үүнтэй адилаар бид Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаснаар Түүнд хайртайгаа мөн Түүн дээр эргэн очихыг хүсэж байгаагаа харуулдаг.

Харин бид хүн бүрийг хайрлаж байгаагаа хэрхэн харуулах вэ? Ерөнхийлөгч Угдорф бас “Хэрэв бид найз нөхдөө хайрладаг бол ‘ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдад’ туслахад өөрсдийгөө зориулдаг. Учир нь энэрэнгүй, амин хувиа хичээдэггүй үйлчлэл хийдэг хүмүүс Есүс Христийн шавь нар мөн.

Тиймээс та дараагийн удаа эцэг эх, ах дүү, найз нөхөдтэйгөө уулзахдаа тэдэнд хайр энэрлээ харуулахын тулд хэрхэн үйлчлэх тухай бодож үзээрэй. Энэ нь тэднийг ч бас таныг ч баярлуулах төдийгүй Тэнгэр дэх Эцэгийг баярлуулах болно.

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Хайртай гэдгээ харуулах нь

**Е**сүс хоёр хүүтэй эцгийн тухай нэгэн түүх хуваалцсан. Эцэг нь усан үзмийн тариалан дээр ажилладаг байсан ба хоёр хүүгээсээ туслахыг хүсжээ. Ууган хүү нь эхлээд татгалзсан ч дараа нь усан үзмийн тариалан дээр туслахаар ирэв. Харин удаах хүү нь тусална гэж хэлсэн ч хэзээ ч ирээгүй. Есүс ууган хүү нь дуулгавартай байснаар эцэгтээ илүү их хайртайгаа харуулсан хэмээн заасан юм.

Энэ түүхийг жүжигчлэн тоглоорой! Дараа нь Тэнгэрлэг Эцэгтээ хайртай гэдгээ харуулахын тулд хийж чадах гурван зүйлийг бич эсвэл зур.



## Эцэг эх байх нь ариун үүрэг юм

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд сунслэг өдөөлтийг эрэлхийл. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг ойлгох нь хэрхэн таны Бурханд итгэх итгэлийг нэмэгдүүлэн, айлчлагч багшийн хувьд харж ханддаг хүмүүсийг тань адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org) хаягаар орж үзнэ үү.

Итгэл, гэр бүл, халамж

Тэнгэрлэг Эцэг хайраар дүүрэн орчинд зөв зарчмуудыг заахад бидэнд туслах гэр бүлүүдийг бий болгосон билээ. Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Хүүхдүүдээ сайшаан урамшуулж, тэврэн, ‘Хайртай шүү’ гэж байн байн хэлж бай мөн талархлаа үргэлж илэрхийлж бай. Шийдэх ёстой асуудлаа хайрлах ёстой хүнээсээ хэзээ ч дээгүүр бүү тавь”<sup>1</sup> хэмээн хэлсэн байдаг.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчөөр үйлчилж байсан Сюзан В.Таннэр: “Тэнгэр дэх Эцэг маань бидний дагах ёстой загварыг харуулдаг. Тэр бидэнд хайртай бөгөөд бидэнд зааж, тэвчээртэй хандаж, биднийг сонгох эрх чөлөөгөө ашиглана гэдэгт итгэдэг. . . . Заримдаа заах гэсэн утгатай сахилгажуулах гэдэг үг нь шүүмжлэхтэй андуурагддаг. Хүүхдүүд, ер нь л бүх насны хүмүүс өө сэвийг нь шүүмжлэн хэлснээр биш, харин хайр, урамшуудлаар зан чанараа хөгжүүлдэг”<sup>2</sup> хэмээн заажээ.

“Хэрэв бид итгэлтэйгээр гэр бүлээрээ залбирч, судар судлан, гэр бүлийн үдэш хийж мөн санваарын адислалуудыг хүлээн авч,

Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахивал . . . хүүхдүүд маань хүнд бэрх дэлхийд тэднийг унагах юу ч тохиолдлоо гэсэн тэнгэр дэх мөнхийн гэртээ бэлтгэгдсэн байх болно”<sup>3</sup> хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Квинтин Л.Күк хэлсэн юм.

### Нэмэлт судрууд

1 Нифай 8:37; 3 Нифай 22:13;  
Сургаал ба Гэрээ 93:40; 121:41

### Бодит түүх

“Намайг сонин уншиж суутал бага насны ач хүү минь дэргэд ирж суув” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс хэлэв. “Ач маань ямар нэг юм хэлэх гээд байгааг сонсоход таатай байлаа. Хэдэн хормын дараа ач маань сонин бид хоёрын дундуур шурган орж ирэхэд, миний гайхсаныг яана. Тэр миний нүүрийг хоёр гараараа барьж, хамраа миний хамарт тулгаад, ‘Өвөө, та энд байна уу?’ гэв.

. . . Энд байна уу гэдэг нь хүүхдийн зүрх сэтгэлийг ойлгож, тэдэнтэй байнга хамт байхыг хэлж байгаа юм. Тэдэнтэй хамт байх

гэдэг нь зүгээр нэг хамт байгаад зогсохгүй, аливаа юмсыг хамтдаа хийхийг хэлнэ. . . .

Бид заах боломжийг төлөвлөж, ашиглах ёстой. . . .

Бага байхад тохиосон суралцах боломж, ялангуяа аав, ээжээсээ сурч мэдсэн зүйлс амьдралд маань нөлөөлж, намайг өдий зэрэгтэй болгосныг нас ахих тусам улам илүү ухаарч ойлгож байна.”<sup>4</sup>

### ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Гэр бүл дэх хайр — бошиглогчийн зөвлөгөө,” *Лиахона*, 2011 оны 8-р сарын 4.
2. Сюзан В.Таннэр, “Did I Tell You . . . ?” *Liabona*, 2003 оны 5-р сар, 74.
3. Квинтин Л.Күк, “Эзэн бол миний гэрэл,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 50-54
4. Роберт Д.Хэйлс, “Бурханы өмнө бидний хүлээсэн үүрэг: Өсвөр үеийнхний эцэг эх, удирдагчдын үүрэг зорилго,” *Liabona*, 2010 оны 5-р сар, 95, 98.

### Үүнийг эргэцүүлэн бод

Яагаад сайн мэдээг хайрын хэл болон үлгэр жишээгээр заадаг вэ?